

## Хариуцлагатай уул уурхай



[Хариуцлагатай уул уурхай](#) by [Inedu Mongol](#)

Уул уурхай нь нарийн төвөгтэй, хурдан явцтай үйл ажиллагаа юм. Хүн амын өсөлт, хотжилт, орлогын өсөлт нь илүү олон барилга, машины хэрэгцээг бий болгож, хэрэглээг тэлснээр уул уурхайн түүхий эд олборлох хэрэгцээ, шаардлагыг нэмэгдүүлсээр байна.

Уул уурхайн салбарын нөлөөгөөр газарзүйн байршлаас үл хамааран байгаль орчин, нийгмийн бүтцэд өөрчлөлт ордог. Энэ нь мөн тухайн газар нутгийн байгалийн тогтоц, ард иргэдийнх нь Амжиргаанд нөлөөлнө. Хариуцлагатай уул уурхайн олон чухал бүрдэл хэсгүүд уг салбар, төр засаг, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээс хамааралтай боловч дараах дөрвөн чиглэл нь хариуцлагатай уул уурхайг тодорхойлогч цөм нь болдог юм. Үүнд:

- Тухайн нутгийн байгаль экологи, түүх соёлын өвийг хадгалах шаардлагыг ойлгох
- Байгаль орчинд ээлтэй уурхайн ашиглалтыг хэрэгжүүлэх
- Уурхайг ашиглах нь ажилчид болон уурхайн бүсэд харьяалагдах ард иргэдэд эергээр нөлөөлөх
- Засаглалын зохистой бүтэцтэй байх

(Илүү дэлгэрэнгүйг <http://www.responsiblemining.net>  
ба <http://miningwatch.ca/publications/2014/2/5/evolving-standards-and-expectations-responsible-mining-civil-society>

